



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/172

Улаанбаатар хот

Бруцеллёз, бог малын мялзан өвчнөөс
сэргийлэх дархлаажуулалтын
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/207 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1051 дүгээр захирамж, Нийслэлийн мал эмнэлгийн газрын даргын А/69 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтыг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, бруцеллёз өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтыг 08 дугаар сарын 15-ны өдрөөс 08 дугаар сарын 28-ны өдрийн хугацаанд шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

2. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад тус дүүргийн өвчинд мэдрэмтгий 1900 тугал, 2083 хурга, 1517 ишиг, бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 5488 хурга, 3812 ишгийг бүрэн хамруулж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ трейд" ХХК (А.Цэрэндагва)-д, дархлаажуулалт хийгдэх товлосон хугацаанд малчдад зар хүргэж, мал, амьтнаа бэлэн байлгах ажлыг зохион байгуулж ажиллахыг хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Бруцеллёз, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 647,500 (зургаан зуун дөчин долоон мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Заавар зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 08 сарын 18 ны өдрийн
А/Х захирамжийн хавсралт



БРУЦЕЛЛЁЗ, БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ВАКЦИНЖУУЛАЛТ БОЛОН ХЯНАЛТЫН АЖИЛД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

1. Шатахуун, холбоо, зарлан мэдээллийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун А-92	л	180	2590	466,200.00
2	Шатахуун А-92 /вакцины татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалтад/	л	70	2590	181,300.00
ДҮН					647,500